



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 117

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 06 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Малын тоо толгойд албан татвар ногдуулах журам”-ын 5.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Улаанбаатар хотод зохион байгуулагдах “Малчин эмэгтэйчүүдийн Манлайлал” зөвлөгөөн өдөрлөг, “Монголын эмэгтэйчүүдийн холбооны ерөнхий зөвлөлийн ээлжит хурал”-д 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрөөс 02 дугаар сарын 05-ны өдрийн хооронд оролцох зарыг малчин эмэгтэйчүүдэд хүргэж, баг бүрдүүлэн оролцуулахыг 1 дүгээр багийн Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (С.Отгонбаатар), 2 дугаар багийн Засаг дарга (Д.Маналмаа) нарт үүрэг болгосугай.

2.Хурал, зөвлөгөөн, сургалтанд шаардагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

3.Хурал, зөвлөгөөнд шаардагдах шатахууны зардал болох 1,030,000 (нэг сая гучин мянга) төгрөгийг “Малын тоо толгойн албан татвар”-ын хураамжаас гаргахыг нягтлан бодогч (Л.Цэнд-Аюуш)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Сугармаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА *Janjir* П.ГАНЧИМЭГ



Сумын Засаг даргын 2023 оны 02-р сарын 02-ны өдрийн 117 дугаар захирамжийн хавсралт



“МАЛЧИН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН – МАНЛАЙЛАЛ” ХУРАЛ, ЗӨВЛӨГӨӨН,  
СУРГАЛТАНД ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Гарах зардал	Хоног	Хүний тоо	Нэг хоногт /төгрөгөөр/	Нийт зардал
1	10 хүний суудалтай машины түрээс	3		100,000	330,000
2	Шатахууны зардал	3		240,000	700,000
Нийт дүн					1,030,000